

Хүн ам зүй

Бичсэн Administrator

2010 оны 5-р сарын 18, Мягмар гариг, 03:22 -

2007 оны 7 сарын байдлаарх Монгол улсын нийт хүн амыг АНУ-ын хүн ам тооллогын товчоо 2,951,786 гэж үзэж байгаа бөгөөд энэ нь дэлхийд 138-д тооцогддог. Харин НҮБ нь хүн амыг 2,629,000 хэмээн тооцож байгаа (АНУ-ын хүн ам тооллогын товчооны тооцооноос 11%-р бага). Монголын Үндэсний Статистикийн Хороо хүн амыг 2,612,900 гэж тооцно.

Хоёр хорш орон болох Хятад ба ОХУ-ын хүн амтай харьцуулахад маш очвухэн юм. Монголын хүн амын ихэнх хувийг Монгол гаралтай хүмүүс эзлэх боловч Казах, Тува, Тунгус үндэстнүүд бага хэмжээгээр бий. 2000 оны тооллогоор Монголын хүн амын осолтийг жилд 1.2% гэж тооцож байна. Нийт хүн амын 59% нь 30-аас доош насны, үүнээс 27% нь 14-оос доош насныхан байна. Энэ харьцангуй залуу ба хурдацтай осож байгаа хүн ам нь бусад хогжиж байгаа орнуудтай адил эдийн засагт нь хүндрэл учруулах болжээ.

Хүн амын 40% нь Буддизм-Ламаизм шашинтай (Товдийн Буддизмтай холбоотой), 30% нь шашингүй, 20% нь Боогийн шашинтай, 6% Христосын шашинтай, 4% нь лалын шашинтан.

Нягтшил багатай Монгол улсын хүн амын нилээд хувь нь сүүлийн үеэс хотод амьдрах болжээ. Тал хувь нь Улаанбаатар ба аймгийн товчдэд амьдарч байна. Орхүүд овор тосгонуудад, зун нь гэрт амьдрах хагас нүүдэлчин байдал нь ходоо давамгайлж байна, гэхдээ бүтэн жилийн турш нэг газартаа байх газар тариалан эрхэлдэг орхүүд ихэсч байгаа. Хүн амын 40% орчим нь нүүдэлчин, эсвэл хагас нүүдэлчин амьдралтай.

Хүн амын 85% нь Монгол үндэстэн бөгөөд үүн дотроос Халх ястан давамгайлна. Эдгээр ястнууд нь голдуу хэлний онцлогоороо ялгагддаг. Монгол угсаатнуудын 90%-г Халх эзэлдэг. Үлдэх 10%-г Буриад, хойд хэсэгт Дорвод, зүүн талд Дарьганга зэрэг эзэлдэг. Түрэг угсаатнууд (Казах, Тува, Уйгур) Монголын хүн амын 7%-г эзлэх бөгөөд үлдэх хүн амд Тунгус үндэстнүүд, Хятадууд, Оросууд багтана. 1991 онд ЗХУ бутарч Монголд үзүүлж байсан тусламж дууссанаар ихэнх Оросууд Монголоос гарчээ.

Хэл

Монгол улсын албан ёсны хэл нь Халх Монгол хэл бөгөөд энэ нь кирилл үсгийг хэрэглэдэг. Нийт хүн амын 90% нь энэ хэлээр ярьдаг ба улс даяар олон аялгатай. Баруун аймгуудад Казах ба Тува хэлнүүд бас яригддаг. Англи хэл нь Монголд хамгийн их яригддаг гадаад хэл, үүний дараа орос хэл орно. Энэ нь социализмын үед монголчууд Оростой харилцаа холбоо маш их байсантай холбоотой, харин 1990-ээд онос хойш англи хэл нь хамгийн их яригддаг гадаад хэл болж байна. Албан ёсоор 30000, хараар 70000 гаруй Монгол иргэн Омнод Солонгост ажиллаж байгаа тул Солонгос хэл нь бас газар авч байна. Ногоо хоршийн хэл болох Хятад хэлийг хүмүүс сонирхох болж, залуучуудын дунд Япон хэл ч бас түгээмэл болжээ. Насанд хүрсэн боловсорсон хүмүүсийн дунд социализмын үед суралцаж байсан Герман, мон бусад зүүн Европын хэлүүдийг мэдэх тохиолдол байдаг. Харин одоо бол залуу Монголчууд нь баруун европод ажиллаж суралцах болсон тул тэндэхийн хэлүүдийг тогс эзэмших болсон.

Монгол хэл нь Монгол хэлний язгуурын хэлнүүдийн нэг. Монгол хэлний язгуур нь Алтайн

хэлний язгуурт хамрагдах нь элбэг богоод энд Түрэг, Тунгус, бас заримдаа Солонгос ба Япон хэлнүүд багтдаг.

Шашин шүтлэг

Тов Азийн нүүдэлчдийн адил боогийн шашин, монх тэнгэрийн шүтлэгийн торлүүд одоогийн Монгол улсын нутагт түгээмэл байжээ. Эдгээрийг аажмаар Товдийн Буддизм эзэмдсэн ч гэсэн боогийн моргол зэрэг нь Монголын шашны соёлд оорийн ул мороо үлдээжээ. Одоо ч гэсэн үйлдэгддэг боо морголийн уламжлалуудын нэг бол овоо тахиx ёслол юм.

1991 онд коммунист засаглал унаснаар шашны эрх чолоотэй болж, коммунизмын олно гол шашин байсан Товдийн Буддизм дахин сэргэж хамгийн түгээмэл шашин болжээ. Христосын шашин, Исламын шашин ч гэсэн дэлгэрч эхлэжээ.

Боловсрол Социализмын үед боловсролын салбар нь хамгийн амжилттай хөгжжээ. Бичиг үсэг үл мэдэх явдал нь нүүдэлчин орхүүдийн хүүхдүүдэд зориулагдсан дотуур байртай сургуулиудын тусламжтайгаар бараг бүтнээрээ арилгагджээ.

1911 оны үндсэний эрх чолооний хувьсгалын дараа хойч залуу үеэ дэлхийн олон улс түмний адил эрдэм боловсролд сургах талаар шинэ дэвшилтэт үзэл санаа сэргэсэн юм. Улмаар 1921 оны ардын хувьсгалын ялалтын үр дүнд анхны бага сургууль (одоогын 3 дугаар сургууль) байгуулагдсан бол 1923 оны 2 сарын 16-ны одор шинэ Монгол улсын анхны дунд сургууль болох 1 дүгээр сургууль үүсэн байгуулагджээ. Энэ сургуульд монгол хэл бичиг, тооны ухаан, англи, франц, герман, хятад хэл зэрэг гадаад хэлээс гадна дэлхийн байдал, бодисын зүй, хувилахуй ухаан, байгаль судлал зэрэг шинжлэх ухааны хичээллүүдийг зааж эхэлсэн байна. 1 дүгээр дунд сургуулийн анхны тогсогчид болох 30 ховгүүд охид 1926 онд Франц, Герман улсад боловсрол эзэмшихээр явцгаасан юм. Тэд бол шинэ Монголын анхны ондор боловсролтой сэхээтнүүд болсон түүхтэй. 1929 он хүртэл ганцхан 1 дүгээр дунд сургууль байсан богоод түүнээс хойш хот, ходоод олон дунд сургуулиуд байгуулагдсан. 1 дүгээр сургууль 1938 онд анхны бүрэн дунд сургууль буюу 10 жилийн сургууль болж оргожсон юм.

1990-ээд оноос дотуур байртай сургуулиудад хийх хоронго оруулалт багассанаар бичиг үсэг үл мэдэх явдал арай ихэсчээ.

Бага, дунд боловсрол нь анх арван жил үргэлжилж байсан боловч 2008 оноос 12 жил болсон.

Монголын үндэсний их сургуулиуд нь бүгд Монгол Улсын Их Сургууль ба Монгол Улсын Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулиудаас үүссэн байна.

1990-ээд оноос хойш хувийн дээд боловсрол олгох институтууд эрчимтэйгээр нэмэгдсэн боловч эдгээр сургуулиудын ихэнх нь "коллеж", "их сургууль" гэсэн нэрдээ хүрэх чадвар алга байна.

Эрүүл мэнд Эрүүл мэнд, асрамжийн байдал Монголд хурдацтай хөгжиж байгаа ба

Хvн ам зvй

Бичсэн Administrator

2010 оны 5-р сарын 18, Мягмар гариг, 03:22 -

vvний vр дvнд дундаж наслалт дээшилж байгаа.

АНУ-ын Тагнуулын тов газрын Дэлхийн мэдээллийн ном (CIA World Factbook)-ынхаар торолтийн хувь хэмжээ (нэг эмэгтэйд ногдох торолтийн тоо) нь 2.25-1.87, хvн амын дундаж наслалт 67-68, Амьд торсон 1000 хvvхдэд ногдох нялхсын эндэгдэл 1.9%-4%; таван наснаас дооших хvvхдийн нас баралт 4.3% байна.

2002 оны байдлаар нийт 33273 эрvvл мэндийн ажилтантай, vvнээс 6823 нь эмч, 788 нь эм зvйч, 7802 нь сувилагч, 14091 нь дунд тvвшний ажилчид байна. Одоогийн байдлаар 10.000 хvн тутамд 27.7 эмч, 75.7 эмнэлэгийн ор тус тус ноогдож байна.